



Хэвлэлийн мэдээ
2019 оны 3-р сарын 1

Холбоо барих
+976 95117771

**АмЧам Монгол оюутан залууст хөрөнгө оруулалт хийж
Ментор Өдөрлөг 2019 зохион байгууллаа**

УЛААНБААТАР, Монгол улс - 2019 оны 3-р сарын 30-ний өдөр Монгол дахь Америкийн Худалдааны Танхимаас (АмЧам Монгол) гурав дахь жилдээ АмЧамын Ментор Өдөрлөг буюу зөвлөгөө өгөх өдөрлөгийг Хаан банк цамхагт амжилттай болж өнгөрлөө.

Оюутан залуус бүтэн өдрийн турш Монголын тэргүүлэх бизнесийн манлайлагчдын илтгэлийг сонсож, шилдэг компаниудын хүний нөөцийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч ажлын байранд үүсч буй шинэ чиг хандлага, эзэмших шаардлагатай ур чадвар болон өөрсдийн нөөц бололцоогоо хэрхэн бүрэн дүүрэн ашиглан карьераа амжилттай ахиулах талаар мэдээлэл сонслоо.

АмЧамын энэ жилийн Ментор Өдөрлөгт их, дээд сургуулиудын төгсөх ангийн 100 оюутан оролцсон бөгөөд АмЧамын гишүүн байгууллагууд болох Хаан Банк, М-Си-Эс, Ард Санхүүгийн нэгдэл, ING, Herbalife Nutrition, Porsche компанийн гүйцэтгэх удирдлагууд урилгаар хүрэлцэн ирж бүтэн өдрийн турш панел хэлэлцүүлэг өрнүүлж, лекц уншиж, ажил мэргэжлийн амжилтаа хэрхэн эхлүүлсэн туршлагаасаа хуваалцаж, оюутнуудад урам зориг өгөх яриа хийж, сонирхсон асуултад хариулав.

Мөн энэхүү өдөрлөгт Хаан Банк, Оюу Толгой, Ард Санхүүгийн нэгдэл, Kempinski Hotel Khan Palace, Porsche, Herbalife Nutrition, ING зэрэг АмЧамын долоон гишүүн компанийн хүний нөөцийн 10 мэргэжилтэн оролцож ажлын өргөдөл, намтараа хэрхэн зөв бичих, ажлын ярилцлагын үеэр ямар ур чадвараа илүү тодотгон ярих талаар практик зөвлөгөө өгч, тодорхой ур чадвар олгох сургалт явуулсан юм.

Өндөрлөгт АНУ-ын Элчин сайдын яам оролцож гадаадад суралцах боломжийн талаар зөвлөгөө өгсөн юм.

Нээлтийн арга хэмжээнд АмЧам Монголын ТУЗ-ийн дарга Ойбек Халилов хэлсэн үгэндээ, "АмЧам Монгол нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд өрсөлдөх чадвартай боловсон хүчнийг хөгжүүлж, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой та бүхнийг өнөөдөр урьсан билээ. Оюутнуудад бодит ур чадвар олгож, урам зориг өгч, зөв сэдэл төрүүлэхийг зорьж байгаа юм. Та бүгдэд хандаж хэлэхэд хамгийн чухал нь зөв хандлагатай бас хариуцлагатай байх юм," гэж онцлов.

АмЧамын энэ жилийн Ментор Өдөрлөгийн ерөнхий ивээн тэтгэгчээр Herbalife Nutrition, Porsche компаниуд, ивээн тэтгэгчээр Хаан Банк тус тус ажиллаа.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм.

АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.